



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/101

Улаанбаатар хот

「Нийслэлийн ерөнхий боловсролын Амгалан」 сургуулийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 3 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Оюу толгой ХХК-иас хандивласан 10,376,000.0 (арван сая гурван зуун далан зургаан мянга) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг хавсралтын дагуу данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн ерөнхий боловсролын Амгалан сургууль (Л.Баянтуул)-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын Амгалан сургууль (Л.Баянтуул)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГА



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 04 өдрийн АНУ дугаар тушаалын хавсралт

Бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Нийслэлийн ерөнхий боловсролын Амгалан сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Үйлдвэр-лэсэн он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	нэр	Эх үүсвэр
1	Дэлгэц	Dell	24 инч	2015	хуучин	ш	20	68,800.00	1,376,000.00	Оюу толгой ХХК	Хандив
2	Процессор	Dell	i5 ram8	2015	хуучин	ш	20	450,000.00	9,000,000.00		
Нийт хөрөнгийн дүн									10,376,000.00		